



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/248

Номгон

Баянхонгор аймгийн 2022 оны "Цэргийн
бүртгэл"-ийг явуулах тухай

Монгол Улсын "Цэргийн албаны тухай хууль"-ийн 34 дүгээр зүйлийн 34.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, Батлан хамгаалахын сайдын "Цэргийн бүртгэл явуулах журам батлах тухай" 2017 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2022 оны Цэргийн бүртгэлийг 01 дүгээр сарын 03-10-ны өдрийг дуустал явуулсугай.

2. Цэргийн бүртгэлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сумын цэргийн бүртгэлээр гаргах, мэдээ, судалгааны жагсаалтыг хоёрдугаар, Цэргийн штабт хүлээн авах сумдын хуваарийг гуравдугаар, хяналтын тооллого явуулах сумдын хуваарь, маршрутыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Цэргийн бүртгэлийг удирдан зохион байгуулж, хяналт тавьж ажиллах байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч, ажлын хэсэг, сумдын Засаг дарга нарт даалгах нь:

а. Цэрэг бүртгэлийн үед нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Улсын онцгой комиссоос тогтоосон халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулж ажиллахыг Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Б.Оюутболд/, Онцгой байдлын газар /хурандаа Ж.Алтангэрэл/, Эрүүл мэндийн газар /Н.Энхжаргал/-т нарт тус тус даалгасугай.

б. Цэргийн бүртгэлээр шаардлагатай тоо, мэдээ, судалгааг гаргаж ажиллахыг Улсын бүртгэлийн хэлтэс /Ц.Мөнхжаргал/, Статистикийн хэлтэс /Э.Ганзориг/, Татварын хэлтэс /С.Рэнцэндагва/-т нарт даалгасугай.

в. Сумдын цэргийн бүртгэл явуулах ажлын хэсгийг захирамжаар томилон, гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтоон, цэргийн бүртгэлийг хүн амын бүртгэлтэй нягт уялдуулан зохион байгуулж, бүртгэл явуулахад шаардлагатай автомашин, ажлын байр, хүн хүчийг гарган ажиллуулах;

601210771

г.Цэргийн бүртгэлийн ажлыг сумдын Засаг даргын Тамгын газрын байранд ариутгал халдваргүйжүүлэлт, агааржуулалтыг 2 цаг тутам тогтмол хийж амны хаалттай иргэдийг байранд нэвтрүүлэх, албан тушаалтнуудад холбогдох хууль тогтоомж, цэргийн бүртгэлийг зохион байгуулан явуулах журмын талаар зааварчилгаа өгч шаардлагатай гарын авлага, материалаар ханган, цэргийн бүртгэлийн ажилд хяналт тавьж ажиллах;

д.Цэргийн бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан иргэд, цэргийн үүрэгтнүүдэд Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдийг хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг шуурхай зохион байгуулах;

е.Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын дагуу цэргийн бүртгэлээр ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нууц хадгалалт, хамгаалалтыг чанд сахиулж, Төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгааг хүн нэг бүрээр гаргуулж авах;

ё. 2004 онд төрсөн 18 нас хүрсэн иргэнийг харъяа сумын бүртгэл явагдах байранд өөрийн биеэр ирж цэргийн бүртгэлд хамруулах;

ж.Хяналтын тооллогыг Баянхонгор, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Баян-Овоо сумдыг хамруулан явуулах;

4.Албан байгууллагадаа ажиллаж байгаа 18-60 насны эрэгтэй ажилчин, албан хаагчдын нэрийн бүртгэлээр бүртгэлийн ажлыг явуулж, мэдээ, тайланг 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Цэргийн штабт ирүүлэхийг Төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нарт даалгасугай.


5.Цэргийн бүртгэлийг тогтоосон хугацаанд хуулийн дагуу сумандаа зохион байгуулж удирдах, иргэдэд батлан хамгаалах тухай хууль, тогтоомжийг сурталчлах, бүртгэлийг сумын цэргийн бүртгэлийн мэдээллийн санг түшиглэн явуулах, иргэний мэдээллийг тодотгон баяжилт хийх, шинээр бүртгэгдсэн бэлтгэл офицер, цэргийн үүрэгтнүүдэд хөтлөгдөх маягт, хүснэгтүүдийг үнэн зөв бүрэн хөтлөх, өдөр тутмын мэдээг тогтоосон хугацаанд Цэргийн штабт утсаар өгч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6.Цэргийн бүртгэл завсардсан, бүртгэлд хамрагдаагүй иргэдийг Монгол Улсын "Зөрчлийн тухай хууль"-ийн 15.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /хурандаа Г.Нэмэхбаяр/-т үүрэг болгосугай.

7. Цэргийн бүртгэлд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар /Д.Энхжаргал/-т зөвшөөрсүгэй.

8.Цэргийн бүртгэлийн явц, чанар, хамралтад байнга хяналт тавьж захиргааны удирдлагаар ханган ажиллаж, тайлан, мэдээ, судалгааг Батлан хамгаалах яам, Зэвсэгт Хүчний Жанжин штабт тогтоосон хугацаанд хүргэн, дүнг 2022 оны 02 дугаар сарын 10-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 408 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Д.Энхжаргал – Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Орлогч дарга: Г.Нэмэхбаяр – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа

Гишүүд: Д.Сарангарав - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Ж.Алтангэрэл – Онцгой байдлын газрын дарга, хурандаа

Б.Оюутболд - Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

Н.Энхжаргал – Эрүүл мэндийн газрын дарга

Ц.Мөнхжаргал - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Х.Ганзориг - Статистикийн хэлтсийн дарга

С.Рэнцэндагва - Татварын хэлтсийн дарга

Г.Бат-Өлзий - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, хошууч

Г.Болдбаатар - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дайчилгааны офицер, ахмад

Д.Дэлгэрсайхан – Аймгийн Засаг даргын дэргэдэх хэвлэл мэдээллийн албаны ажилтан

Нарийн бичгийн дарга: Т.Мөнхбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүтгэлийн офицер, хошууч

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/ЗУ.Д дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт

ЦЭРГИЙН БҮРТГЭЛЭЭР ГАРГАХ БҮРТГЭЛ,
МЭДЭЭ, СУДАЛГААНУУД

Нэг. Бүртгэлүүд

Сумын цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний нэрийн бүртгэл

1. Бэлтгэл офицерын нэрийн бүртгэл /Маягт №1/
2. Бэлтгэл ахлагчийн нэрийн бүртгэл /Маягт №1/
3. Бэлтгэл байлдагч, түрүүчийн нэрийн бүртгэл /Маягт №1/
4. Цагдаа, Тагнуул, Шүүхийн шийдвар гүйцэтгэх алба, Шүүхийн шинжилгээний албанд цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр алба хаасан төрийн тусгай алба хаагчийн нэрийн бүртгэл /Маягт №1/

Сумын цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний нэрийн бүртгэл

5. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасан иргэдийн нэрийн бүртгэл /Маягт №2/
6. Алслагдсан сум, сум дундын болон багийн эмнэлэгт эмч, сум, багийн сургуульд багшаар ажиллаж байгаа иргэдийн нэрийн бүртгэл /Маягт №2/
7. Дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан иргэдийн нэрийн бүртгэл /Маягт №2/
8. Цэргийн жинхэнэ алба хаагаагүй иргэдийн нэрийн бүртгэл /Маягт №2/
9. Цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүдийн нэрийн бүртгэл /Маягт №2/
10. 2022 оны цэргийн бүртгэл завсардсан, бүртгэлд хамрагдаагүй цэргийн бэлтгэл үүрэгтний нэрийн бүртгэл /Маягт №3/
11. 16, 17 настай идэрчүүдийн бүртгэл
12. Автомашин, трактор, зам барилгын техникийн бүртгэл /Маягт № ЦШ-16/
13. Чиргүүл, мотоциклийн бүртгэл /Маягт № ЦШ-17/
14. Тайван цагт цэргийн албанд эрүүл мэндээр тэнцэхгүй иргэдийн бүртгэл /Маягт № ЦШ-13/

Хоёр. Мэдээ, судалгаанууд

1. Бэлтгэл офицерын тоон бүртгэлийн нэгдсэн мэдээ /Маягт №4/
2. Бэлтгэл ахлагчийн тоон бүртгэлийн нэгдсэн мэдээ /Маягт №5/

3. Бэлтгэл байлдагч, түрүүчийн тоон бүртгэлийн нэгдсэн мэдээ /Маягт №6/
4. Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний тоон бүртгэлийн нэгдсэн мэдээ /Маягт №7/
5. Цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүдийн тоон бүртгэлийн нэгдсэн мэдээ /Маягт №8/
6. 2022 оны цэргийн нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний тоон бүртгэлийн дүнг 2021 жилийн эцсийн хүн амын статистик суурин мэдээтэй харьцуулсан судалгаа /18-60 насны/ /Маягт №9/
7. Дайчилгааны бэлтгэл нөөцийн байршлын тоон бүртгэлийн нэгдсэн мэдээ /Маягт №10/
8. 16-17 насны идэрчүүдийн судалгаа
9. Цэргийн албанд татагдаж болох залуучуудын урьдчилсан боломж
10. Автомашин, трактор, зам барилгын техникийн мэдээ /Маягт № ЦШ-9/
11. Эрчүүдийн мэдээ /Маягт № ЦШ-4/
12. Ангийн бууны мэдээ /Маягт №ЦШ-10/
13. Акт морьд, хувийн өмчийн ердийн хөсөг, түүний тоног хэрэгслийн мэдээ /Маягт № ЦШ-11/
14. Дүйцүүлэхалбыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгах ажлын гүйцэтгэлийн мэдээ /Маягт СТ-Х2/
15. 1996 онд төрсөн мөнгөн төлбөр төлөх иргэдийн судалгаа /Маягт СТ-Х4/
16. Цэргийн албыг гэрээгээр болон биеэр дүйцүүлэн хаахаар санал гаргасан иргэдийн бүртгэл, судалгаа /Маягт СТ-Х6/


Аймгийн Засаг даргын 2021 оны ... дугаар
сарын ... -ны өдрийн ... дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

СУМДЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭ, СУДАЛГААГ ХҮЛЭЭН
АВАХ ХУВААРЬ

№	Сумдын нэр	Хуваарь	
		Өдөр	Цаг
1	Баянговь, Галуут, Баянцагаан, Өлзийт, Жинст	1/18	09.00
2	Шинэжинст, Баян-Өндөр, Жаргалант, Богд, Баянлиг	1/19	09.00
3	Хүрээмарал, Баянбулаг, Заг, Баацагаан, Баян-Овоо	1/20	09.00
4	Бууцагаан, Бөмбөгөр, Эрдэнэцогт, Гурванбулаг, Баянхонгор	1/21	09.00

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 4/21 дугаар захирамжийн 4 дүгээр хавсралт

ХЯНАЛТЫН ТООЛЛОГО ЯВУУЛАХ СУМДЫН ХУВААРЬ, МАРШРУТ



oOo